

НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2026 оны 06 сарын 03

Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратеги зорилго, зорилтыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн:

Нийслэлийн Өргөө амаржих газарт амаржих газарт 2026 оны эхний 5 сарын байдлаар нийт 2168 эх амаржиж, 2181 амьд төрөлт бүртгэгдсэн, өмнөх оны мөн үеэс төрөлт 177 тохилдолоор буурсан, 686 эхийг кесар мэс заслаар төрүүлсэн нь 31.5%-ийг эзэлж байна. 2026 оны эхний 5 сарын байдлаар Эхийн ноцтой хүндрэл 4 бүртгэгдсэн, өмнөх оны мөн үеэс 3 тохиолдолоор буурсан. Нярайн эндэгдэл эхний 5 сарын байдлаар 5 тохиодол бүртгэгдсэн, нярайн эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд 4.0 ногдож, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 промилээр буурсан, хоног болоогүй нас баралт, үндсэн оношны зөрөө бүртгэгдээгүй байна.

Амаржих газрын даргын 2026 оны 03 сарын 26-ны өдрийн А/26 дугаар тушаалаар “Эхийн ноцтой хүндрэл, эхийн болон перинатал эндэгдлийг магадлан хэлэлцэх, хариу арга хэмжээ авах журам”-ыг баталсан. Тушаалын хэрэгжилтийг хангах, эх нярайн өвчлөл, хүндрэлийг бууруулах зорилготой нярайн эндэгдлийн 5, эхийн ноцтой хүндрэлийн 1 тохиолдлыг 4 удаагийн хурлаар хэлэлцэн 16 шийдвэр, зөвлөмж гарган, 16 үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 90%-тай байна.

Хурлын шийдвэрийн дагуу хэрэгжүүлсэн үйл ажиллагаа:

1. “Хэвийн төрөлт болон эмгэг төрөлт удирдах арга зүй”, “Төрөлт сэдээх болон эрчимжүүлэх” сэдвийн хүрээнд эх барих эмэгтэйчүүдийн эмч нарт зориулсан сургалтыг зохион байгуулж байна. Энэхүү сургалтыг зөвлөх, тэргүүлэх, ахлах болон залуу эмч нарын бүлэг болгон удирдамжийн дагуу үе шаттайгаар зохион байгуулж байна. 2026 оны 05 сарын 06-ны өдөр залуу эмч нар болон ахлах зэрэгтэй эмч нарт зориулсан сургалтыг, АУ-ны магистр, Клиникийн профессор, эх барих эмэгтэйчүүдийн зөвлөх зэргийн эмч, Дутуу тээлтийн тасгийн зөвлөх эмч Д.Наранцацралт удирдан явуулсан. Сургалтын албанаас эх барих эмэгтэйчүүдийн ахлах зэргийн эмч Т.Нямцэцэг, Даатгалын эмч Б.Ундром нартай хамтран эмнэлзүйн тохиолдолд суурилсан сургалтыг зохион байгуулсан.
2. Нярайн эндэгдлийг бууруулах чиглэлээр ЭПЭТХ-аас гарсан шийдвэрийн дагуу Ажлын байрны сургалтыг нярайн тасгийн нийт эмч, сувилагч нарт 10 удаа, 8 сэдвээр, давхардсан тоогоор нийт 76 эмч, мэргэжилтнүүдийг оролцуулан зохион байгуулсан.
3. “Эмч, эмнэлгийн мэргэжилтний жижүүрийн үүрэг гүйцэтгэх журам”-ыг дахин сануулах мэдээллийг нийт 76 эмч, 20 резидент эмчид танилцуулсан.

ЭМС-ын 2024 оны А/112 дугаар тушаал “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах журам”-д заасны дагуу тохиолдол бүртгэл, мэдээллийн <https://eburtgel.hdc.gov.mn> цахим сайтад Амаржих газрын 102 эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдээллийг бүртгэн оруулж, тохиолдлыг бүртгэн, залруулах арга хэмжээ авч ажиллаж байна. Амаржих газрын тохиолдлын тайланг 2026 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэн дүгнэхэд Тохиолдол 1А (80.7%), тохиолдол 1Б (9.6%), тохиолдол 2 (8.4%), тохиолдол 1 (1.2%) тус тус байна. Таагүй тохиолдол нь эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой үйлчлүүлэгчид сөрөг үр дагавар үзүүлсэн нөхцөл байдал үүсч ЭМТҮЧАБ-ын албаны түвшинд үндсэн шалтгааныг тодорхойлж хариу арга хэмжээ авч ажиллаж байна.

“Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал”-ыг хангах зорилтын хүрээнд 5 удаагийн сургалтаар 360 эмч, мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгуулсан. Хэцүү үйлчлүүлэгч болон Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, Зөв танин тодруулах сэдвээр нийт 28 эмч нарт мэдлэг сэргээх сургалт, тохиолдолд суурилсан хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын дотоодын хяналт үнэлгээ хийж сайжруулах хүрээнд 2025 онд бүртгэгдсэн эхийн ноцтой хүндрэл, давтан мэс засал, эмнэлгийн тусламж үйлчилгээний дутагдал, оношны зөрөө, амьгүй төрөлт, хоног болоогүй нас баралтын тохиолдолуудад дүн шинжилгээ хийж нийт эмч нарт мэдээллийг хүргэн, эх, нярайн өвчлөл, хүндрэлээс сэргийлэх чиглэлээр зөвлөмж, үйл ажиллагааны чиглэлийг танилцуулсан.

ЭМС-ын 2022 оны А/352 дугаар тушаал “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал”, ЭМС-ын 2023 оны А/220 дугаар тушаал, Үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэх журам, НӨАГ-ын даргын 2023 оны А/51, А/52 дугаарын тушаалын хэрэгжилтэд үнэлгээ хийж, ЭМТҮЧАБА-аас удирдамж, хяналтын хуудасны дагуу Сувилахуйн алба, СЭШХАА, ХСХА, Эмзүйн албадууд хамтран хяналт үнэлгээг хийж ажилласан. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 6 зорилтын хүрээнд хяналт үнэлгээний дундаж 81%-тай үнэлэгдсэн, цаашид сайжруулах арга хэмжээ асуудлыг холбогдох алба, тасгуудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

2026 оны эхний 5 сарын байдлаар ЭМТҮЧАБА болон Эмнэлзүйн тасгийн чанарын багийн гишүүдтэй хамтран төлөвлөгөөт болон яаралтай кесар мэс заслын төрөлтөд Нярайн эрт үеийннэн шаардлагтай тусламж, халдвараас сэргийлэх хяналтын хэрэгжилтэд үнэлгээ хийн эмч, мэргэжилтнүүдэд зөвлөмж өгч ажилласан. Үүний үр дүнд кесар мэс заслаар төрсөн нярай бүрд дулаан алдалтаас сэргийлэх, эх нярайг арьс арьсаар шүргэцүүлэх үйл ажиллагаа 100% хэрэгжсэн.

ЭМС-ын 2025 оны А/408 дугаар тушаал Мансууруулах, Сэтгэцэд нөлөөт эмийн хэрэглээ, зарцуулалт, хадгалалт чиглэлээр дотоод хяналт үнэлгээг хэрэгжүүлж ажиллав. 2026 оны 04 дүгээр 02-ны өдрийн Амаржих газрын даргын

баталсан удирдамжийн дагуу мэс засал/мэс ажилбарийн үед мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм хэрэглэсэн үйлчлүүлэгчдийн цахим түүхийг санамсаргүй түүврийн аргаар сонгож хяналтын хуудсын дагуу үнэлгээг хийсэн, дунджаар 90% үнэлэгдсэн ба 7 асуудлыг илрүүлж, 4 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан байна.

Цус сэлбэлтийг зохицуулах зөвлөл карте цахим системд цус цусан бүтээгдэхүүн сэлбэсэн зөвшөөрлийн маягт протоколд 44 удаагийн хяналт хийхэд 90.9% байна. Мөн цус цусан бүтээгдэхүүн сэлбэх 58 тохиолдолд хяналтын үнэлгээ хийхэд 93.5%, зөвшөөрөл авах хяналтын 58 хуудсаар үнэлгээ хийхэд 91.3%, цус цусан бүтээгдэхүүн сэлбэх 29 хуудсаар ижил мэргэжилтэний үнэлгээ хийхэд 82.3%, биологийн тохироо тодорхойлох 29 хуудсаар үнэлгээ хийхэд 85.9% тус тус үнэлэгдсэн.

2026 оны эхний 5 сарын байдлаар түүврийн аргаар 120 хүнд судасны гуурсын тандалтыг хийсэн бөгөөд халдварын сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй, шээлгүүртэй холбоотой шээсний замын халдвар илрүүлэх тандалтыг түүврийн аргаар 125 үйлчлүүлэгчид хийхэд халдварын сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй байна. ЭМС-ын 2019 оны А/537 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Эрүүл мэндийн ажилтны гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэг дадлыг үнэлэх загвар хуудас”-аар 1-р улиралд 3 удаа үнэлгээ хийв. Амаржих газрын 9 тасагт Эрүүл мэндийн сайдын А/537 тоот тушаал зургаадугаар хавсралт “Цэвэрлэгээний чанарт дотоод хяналт хийх загвар” хуудсын дагуу их цэвэрлэгээнд үнэлгээ хийсэн. Үнэлгээний дундаж-91.6%-тай үнэлэгдсэн байна.

Тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах туршлага солилцох үйл ажиллагаа:

Эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслыг амаржих газарт нутагшуулж, эмэгтэйчүүдийн нийт мэс заслын 75%-ийг дурангийн аргаар хийж байна. БНХАУ-ын Хөх хотын Эх, хүүхдийн төв эмнэлэгт нийт 5 эмч, 8 сувилагч 5 чиглэлээр туршлага судлан тусламж үйлчилгээнд нэвтрүүлж ажиллаж байна. БНСУ-ын “София” эмэгтэйчүүдийн эмнэлэгт 2026 оны эхний хагас жилийн байдлаар гадаад сургалтад нийт 13 эх барих, эмэгтэйчүүдийн эмч, мэс заслын сувилагч 1, нярайн сувилагч 1 хамрагдан туршлага судласан.

Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал хувь хүний нууцийг хадгалах, бусдад сонсогдохгүйн улмаас буруу мэдээлэл дамжуулахаас сэргийлэн цахим бүртгэлийн хэсэгт микрофон, чанга ярих төхөөрөмж авч байрлуулсан. Амбулаторийн тасгаар өдөрт 300-400 үйлчлүүлэгч тогтмол цаг товлож үйлчилгээ авдаг бөгөөд үйлчлүүлэгч бүрт эмчийн үзлэгийн цаг нь ойлгомжтой дэс дараалал болон үзлэг хийгдэж байгаа үйлчлүүлэгчийн мэдээлэл гарсанаар сэтгэл ханамж дээшилсэн. Мэдээллийн самбарт нэмэлтээр үйлчлүүлэгчид зориулсан зарлал мэдээлэл оруулах боломжтой. Эмчийн үзлэгийн өрөөнүүдэд 8 ширхэг дэлгэц байршуулсан.

2026 оны эхний 5 сарын байдлаар Амбулаторийн сэтгэл ханамжийн үнэлгээ 83.4%-тай байгаа бөгөөд 2025 оны мөн үетэй харьцуулахад 0.1%-иар өссөн байна. Хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг 13 асуумжийн дагуу QR код үүсгэн эмнэлзүйн 8 тасгийн 477 үйлчлүүлэгчдийг судалгаанд хамруулж, 4 чиглэлээр сайжруулах санал өгч, эерэг сэтгэл ханамж 92.5%-тай байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын албанд 2026 оны эхний хагас жилийн байдлаар иргэд үйлчлүүлэгчдээс нийт 11 гомдлыг бүртгэн үүнээс үндэслэлгүй гомдол 3, санал 1, хүсэлт 1 ирсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 8 тохиолдол буюу 53.3%-иар буурсан эерэг үзүүлэлттэй байна. Гомдлын агуулгын хувьд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой гомдол 3 буюу 37.5%-иар буурсан, Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс ирсэн гомдол 3 буюу 25%-р буурсан үзүүлэлттэй байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног байна. Үйлчлүүлэгчид өгөх мэдээлэл дутмаг байдалтай холбоотой гомдол бүртгэгдээгүй. Мөн 11-11 төвөөс нийт 62 удаа, 182 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд талархлын захидал ирсэн нь байгууллагын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эерэг үнэлгээ нэмэгдэж байгааг харуулж байна, эдгээр талархалыг байгууллагын дотоод мэдээллийн 8 сувгаар түгээж, ажилтнуудад уламжлан хамт олны дунд урамшуулах арга хэмжээг зохион байгуулсан. Өргөдөл, гомдлын тоо буурч, талархлын тоо нэмэгдсэн нь байгууллагын тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч байгааг илтгэж байна.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ЭМТҮЧАБА-НЫ ДАРГА

М.ЭНХДАЛАЙ